

Соёлын сайд, Боловсрол, шинжлэх ухааны
сайдын 2023 оны дугаар сарын-ны
өдрийн тоот хамтарсан тушаалын хавсралт

ПАЛЕОНТОЛОГИ, АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ, МАЛТЛАГА СУДАЛГАА ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийхэд Соёлын өвийг хамгаалах тухай, Зөвшөөрлийн тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу олгосон энгийн зөвшөөрлийг үндэслэн хэрэгжүүлнэ.

1.3.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийхэд Газрын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Улсын хилийн тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ журмыг мөрдөнө.

1.4.Энэ журам нь палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах чиглэлтэй хайгуул, малтлага судалгаа хийхэд нэгэн адил үйлчилнэ.

Хоёр.Нэр томьёо

2.1.Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1."хайгуул судалгаа" гэж шинжлэх ухааны арга зүйн дагуу соёлын биет өвийн нээж илрүүлэх, бүртгэн баримтжуулах, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах зорилгоор хийх палеонтологи, археологийн судалгааны ажлын хэлбэрийг;

2.1.2."малтлага судалгаа" гэж шинжлэх ухааны арга зүйн дагуу газрын гадрага ба газрын хэвлийд хадгалагдан үлдсэн соёлын үнэт зүйлсийг илрүүлэн судлах зорилгоор хийх палеонтологи, археологийн судалгааны ажлын хэлбэрийг;

2.1.3."эрдэм шинжилгээний судалгаа" гэж палеонтологи, археологийн шинжлэх ухааны тодорхой сэдвийн хүрээнд шинэ ба нэмэлт мэдлэг бий болгох зорилготой хайгуул, малтлага судалгааны ажлын чиглэлийг;

2.1.4."авран хамгаалах судалгаа" гэж соёлын биет өвийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох, газрын гадрага ба газрын хэвлийг хөндөхөөс өмнө палеонтологи, археологийн хайгуул, малтлага хийж, соёлын биет өвийг аюулгүй болгох зорилготой судалгааны ажлын чиглэлийг;

2.1.5."судалгааны анги" гэж мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаас палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажил

гүйцэтгэхээр томилсон, зохих хүний нөөц, багаж, техник, тоног төхөөрөмж бүхий бие даасан эсхүл хамтарсан багийг;

2.1.6."зөвшөөрөл" гэж Зөвшөөрлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1-д заасныг;

2.1.7."олдвор" гэж палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын үр дүнд илэрч олдсон, эд зүйл илэрхийлэх (юу болох) боломжтой нэгдмэл болон салангад түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг;

2.1.8."судалгааны дээж" гэж палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнд илэрч олдсон бие даан эд зүйл илэрхийлэх боломжгүй хэсэг, эсхүл олдворын эд зүйл илэрхийлэх шинж чанарыг алдагдуулахгүй арга, хэлбэрээр дээжлэн авсан хэсгийг.

Гурав.Эрдэм шинжилгээний байгууллагад тавих шаардлага

3.1.Палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага /цаашид "эрдэм шинжилгээний байгууллага" гэх/ эрхлэн явуулна.

3.2.Эрдэм шинжилгээний байгууллага нь палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй, олдвор, судалгааны дээж хадгалах зориулалтын байр танхимтай, хэмжилт, материал бүтэц болон бусад чиглэлээр судалгаа боловсруулалт хийх техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий лабораторитой байна.

3.3.Эрдэм шинжилгээний байгууллага нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажил хийж болно.

3.4.Эрдэм шинжилгээний байгууллага нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийхээр гэрээ байгуулах, судалгаа хийхийг хориглоно.

Дөрөв.Судалгааны ангид тавих шаардлага

4.1.Судалгааны анги нь эрдэм шинжилгээний байгууллагын захирлын тушаалаар томилсон удирдагч, эрдэм шинжилгээний ахлагчтай байна.

4.2.Удирдагч нь судалгааны ангийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах үндсэн үүрэгтэй бөгөөд Монгол Улсын иргэн, палеонтологи, археологийн чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай, доктор ба түүнээс дээш зэрэгтэй, тухайн байгууллагын орон тооны ажилтан байна.

4.3.Эрдэм шинжилгээний ахлагч нь судалгааны ангийн өдөр тутмын судалгааны ажлыг чиглүүлэн зохион байгуулж ажиллах үндсэн үүрэгтэй байх бөгөөд Монгол Улсын иргэн, палеонтологи, археологийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай, магистр ба түүнээс дээш зэрэгтэй, тухайн байгууллагын орон тооны ажилтан байна.

4.4.Судалгааны анги нь судалгааны ажлын цар хүрээнээс шалтгаалан хэд хэдэн эрдэм шинжилгээний ахлагчтай байж болно.

4.5.Судалгааны анги нь удирдамжтай байна. Удирдамжийг эрдэм шинжилгээний байгууллагын захирал батална.

4.6.Энэ журмын 4.7-д заасан удирдамжид судалгааны ангийн зорилго, гүйцэтгэх үйл ажиллагаа, бүрэлдэхүүн, маршрут, судалгааны объект, хугацаа, хүлээгдэж буй үр дүн болон зардлын задаргаа зэрэг мэдээллийг агуулсан байна.

4.7.Судалгааны анги нь эрх бүхийн этгээдээс олгосон зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бөгөөд аливаа улс төр, нам эвслийн үйл ажиллагаа, орон нутгийн ард иргэдийн, эсхүл хуулийн этгээд хоорондын зөрчил, мөргөлдөөнд хөндлөнгөөс оролцохгүй.

4.8.Судалгааны анги нь сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн тухайн орон нутагт зохион байгуулагдах нийтийг хамарсан баяр ёслол, наадмын үйл ажиллагаанд оролцож болно.

Тав.Зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох

5.1.Эрдэм шинжилгээний байгууллага нь палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын зөвшөөрөл хүссэн өргөдлөө Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.2 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд нийцүүлэн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

5.2.Эрдэм шинжилгээний байгууллага нь палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах чиглэлтэй хайгуул, малтлага судалгаа хийх тохиолдол бүр энэ журмын 5.1-д заасан өргөдлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

5.3.Эрдэм шинжилгээний байгууллага дэлхийн өвийн дурсгалт газар болон хууль тогтоомжоор тусгайлан хамгаалалтад авсан газарт палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх бол хамгаалалтын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдтэй урьдчилан зөвшилцөж, холбогдох хуульд заасан зөвшөөрлийг авсан байна.

5.4.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2, 5.3 дугаар зүйлд заасныг журамлан магадлан шалгаж, зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

5.5.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрлийн баримт бичгийг эрдэм шинжилгээний байгууллагад олгоно.

5.6.Эрдэм шинжилгээний байгууллага нь палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх зөвшөөрөл хүссэн өргөдлөө тухайн судалгааны ажил эхлэхээс хуанлийн 25-аас доошгүй хоногийн өмнө соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.7.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх зөвшөөрлийн хугацааг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27^{1.3} дахь хэсэгт заасны дагуу сунгаж болно.

5.8.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх зөвшөөрлийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27^{1.4} дэх хэсэгт заасны дагуу хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.

5.9.Эрдэм шинжилгээний байгууллага зөвшөөрлийн хүрээнд гүйцэтгэх судалгааны ажлыг бусад этгээдээр гүйцэтгүүлэхийг хориглоно.

5.10.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх зөвшөөрөл олгосон, сунгасан, хүчингүй болгосон шийдвэрийг гарсан даруйд аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

Зургаа.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх

6.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх ажлыг жил бүрийн 3 дугаар сарын 1-нээс 11 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэнэ.

6.2.Судалгааны анги палеонтологи, археологийн хайгуул малтлага судалгааны ажлыг зөвшөөрлийн баримт бичигт заасан газар, тогтоосон хугацаанд палеонтологи, археологийн судалгааны арга зүйн дагуу гүйцэтгэнэ.

6.3.Судалгааны анги дараах үүрэгтэй:

6.3.1.палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааг эхлүүлэхээс өмнө тухайн сум, дүүргийн Засаг даргад судалгааны ажлын талаар урьдчилан мэдэгдэх;

6.3.2.судалгааны ангийн хотхоныг дурсгалын харагдах сүр бараа, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй алслал бүхий орчинд, хамгаалалтын бүсийн гадна байгуулах;

6.3.3.хотхоны хог хаягдлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тухай бүр булшлах зэргээр байгаль орчныг бохирдуулахаас сэргийлэх;

6.3.4.орон нутгийн захиргааны байгууллага, ард иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн, судалгаатай холбоотой мэдээллээр хангах, судалгааны ажилд оролцох боломжийг бүрдүүлэх;

6.3.5.судалгааны ажлын явцыг иргэдэд нээлттэй танилцуулах;

6.3.6.судалгааны ажилд оролцогчийн амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;

6.3.7.хууль тогтоомжоор тусгайлан хамгаалалтад авсан газарт хайгуул, малтлага судалгаа хийх бол холбогдох дэглэмийг мөрдөх;

6.3.8.судалгааны явцад илэрсэн олдвор, судалгааны дээжийг тухай бүр бүртгэн баримтжуулж, аюулгүй орчинд түр хадгалах;

6.3.9.судалгааны ажил дууссаны дараа малтлагын талбайг аюулгүй болгон нөхөн сэргээж, орон нутгийн холбогдох албан тушаалтанд хүлээлгэх өгөх.

6.4.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийхэд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 28.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

6.5.Судалгааны баг палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх явцад түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн өндөр ач холбогдолтой ховор олдвор ба дурсгалт газар илэрсэн бол цаашдын судалгаа, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлах саналыг бэлтгэж, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад яаралтай мэдэгдэнэ.

6.6.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 6.5-д заасан саналыг судалж, шаардлагатай дэмжлэг тусалцааг үзүүлж болно.

6.7.Судалгааны анги дараа жил судалгааны ажлыг үргэлжлүүлэх бол малтлагын талбайг аюулгүй болгон харуул хамгаалалттайгаар үлдээж болно.

6.8.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэргүй олдвор, судалгааны дээжийг бусдын өмчлөл ба эзэмшилд шилжүүлэхийг хориглоно.

Долоо.Судалгааны ажлыг тайлагнах

7.1.Судалгааны ангийн удирдагч тухайн жилд багтаан судалгааны ажлын тайланг бэлтгэж, байгууллагын удирдлагад хүлээлгэн өгнө.

7.2.Эрдэм шинжилгээний байгууллага тухайн жилд гүйцэтгэсэн судалгааны ажлын тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.3.Судалгааны ажлын тайлан дараах шаардлагыг хангасан байна:

7.3.1.бичвэр орчин цагийн монгол хэлний найруулга зүйд нийцсэн, техникийн алдаагүй, монгол хэлээр, кирилл үсгээр бичигдсэн байх;

7.3.2. судалгааны ажлын явц, үр дүнг бүрэн илэрхийлсэн бичвэр, гар зураг, гэрэл зурагтай байх;

7.3.3.гэрээ, удирдамж, болон судалгаанд зарцуулсан зардлын задаргааг хавсаргах;

7.3.4.гадаад хэл дээрх холбогдох баримтын монгол орчуулгыг хавсаргах;

7.3.5.судалгааны явцад олж илрүүлсэн олдвор, эд зүйлсийн хийгдсэн материал, хэмжээ, жин, зориулалт, төрх байдлыг илэрхийлсэн жагсаалтыг хавсаргах;

7.3.6.олдвор, эд зүйлсийн шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг хавсаргах;

7.3.7.судалгааны явцад илрүүлсэн дурсгалын солбицол бүхий жагсаалтыг хавсаргах; /Солбицлыг UTM системээр тогтоох/

7.3.8.судалгааны ангийн удирдагч, эрдэм шинжилгээний ахлагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулсан байх.

7.4.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тайланд хөндлөнгийн шинжээчээр дүгнэлт гаргуулна. Шинжээчийн дүгнэлтээр тайлан энэ журмын 7.3 дахь хэсэгт заасан шаардлагад нийцээгүй бол эрдэм шинжилгээний байгууллагад буцаан хүргүүлнэ.

7.5.Эрдэм шинжилгээний байгууллага энэ журмын 7.5-д заасан тайланг ажлын 5 хоногт багтаан шаардлагад нийцүүлэн буцаан хүргүүлэх үүрэгтэй.

7.6.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд гүйцэтгэсэн палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын тайланд мэргэжлийн зөвлөлөөр нэгдсэн дүгнэлт гаргуулна.

7.7.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд гүйцэтгэсэн палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын тайланг, нэгдсэн дүгнэлтийн хамт Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлнэ.

7.8.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын тайланг ашиглах асуудлыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 22.1 дэх хэсэгт заасан “Соёлын өвийг бүртгэл мэдээллийн санд бүртгэх, мэдээллийг ашиглах журам”-аар зохицуулна.

8.Бусад зүйл.

8.1.Энэ журмын зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль заасны дагуу хариуцлага ногдуулна.

8.2.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын явцад үнэлгээ хийх, тайланд шинжээчийн дүгнэлт гаргуулахад шаардагдах зардлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санхүүжүүлнэ.